

АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл (MERESP) IDA CREDIT# P174116
Байршил	Улаанбаатар хот, Монгол улс
Ажлын даалгаврын гарчиг	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах сургалтын материалыг видео болгон хөрвүүлэх
Гэрээний төрөл	Зөвлөхийн бус үйлчилгээ
Шаардлагатай хэл	Монгол хэл
Гэрээний хугацаа	2024 оны 08 сарын 09-ний өдрөөс эхлэн 2024 оны 11 сарын 20 хүртэл

Үндэслэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-аас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (MERESP) хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажиллагчдад түр хугацааны хөнгөлөлт үзүүлэх зорилготой. Төсөл нь дараах үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсэг 1: хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагатай нягт хамтран ажилласанаар ажил олгогч болон ажил хайгчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 2: хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 3: хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цар хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 4: зохих шалгуур хангасан ажиллагсад болон ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийг түр хугацаагаар хөнгөлөх боломжийг олгоно.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. (а) Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн үнэлгээний зөвлөмжид үндэслэн холбогдох арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх; (б) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем (LMIS) болон мэдээллийн дэвшилтэд технологид суурилсан ажил зүүчлалын үйлчилгээг нэвтрүүлэх (в) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын зохион байгуулалт, сургалтын орчныг сайжруулж, байр/танхимыг засварлах; (г) Техникийн туслалцаа, боловсон хүчнийг сургах замаар төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Аймаг, дүүрэг болон сум, хороо бүрт ажил хайгч, ажлын байрны бүртгэл, ажил хайгчдад зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ хийх, ажилд зуучлах, болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үйлчилгээг үзүүлдэг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд байдаг.

2023 оны 10-р сарын байдлаар сүүлийн хоёр жилийн статистикийг харьцуулан үзэхэд нилээд өөрчлөлт гарсан байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд ажил хайгчдын тоо 71%, бүртгэлтэй ажил хайгчдын тоо 73%-аар өссөн. Харин ажлын байрны тоо 5%, ажилд зуучлагдсан хүний тоо 79%, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 60%-иар тус тус буурсан байна.

Ажил хайгч иргэдэд зөвлөгөө өгөх, ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үр ашиг нь мэргэшсэн, чадварлаг ажилтнуудын үйлчилгээ үзүүлэхээс ихээхэн хамаардаг. Гэвч хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар/хэлтэст мэргэшсэн боловсон хүчнийг авч үлдэхэд хүндрэлтэй байгаа нь цалин бага, ажлын хэт ачаалал, шинээр ажилд орсон боловсон хүчнийг чадавхжуулах системчилсэн сургалт дутмаг зэргээс шалтгаалж байна.

Тодруулбал, 2020-2023 оны хооронд хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн 60% нь шинэ ажилтан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхийн тулд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээ, Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08), Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах үр чадварын багц, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр баримталж буй үндэсний бодлого, хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88 дугаар конвенцын талаар сайн мэдлэгтэй байх шаардлагатай.

2021-2023 оны хооронд нийт ажилчдад Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ/Профайлинг болон Хөдөлмөрийн нэгдсэн систем “ejob”-ийн сургалтаас өөр чадавхжуулах сургалт зохион байгуулаагүй байна.

Түүнчлэн ХНХЯ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд МУ-н Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн “ejob” платформыг хэрэглээнд нэвтрүүлсэн. “ejob” платформаар дамжуулан Үндэсний Ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08)-ын нэр томъёо, ажил мэргэжлийн индекс код, Ур чадварын багцыг (Skill set) ажил зуучлалын үйлчилгээнд хэрэглэдэг болох, ингэснээр сул ажлын байранд тохирох үр чадвар бүхий ажилтныг зуучлах боломж бүрдэнэ. Гэвч хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан хөдөлмөрийн салбарын ажилтнууд хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтын талаар мэдлэг дутмаг, Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT)-ын хэрэглээ, ажил мэргэжлүүдийн ангилал, кодлолын талаар зохих мэдлэггүй байгаа учир ажлын байрны бүртгэл, ажил хайгчийг ажилд зуучлахад хүндрэлтэй байдаг.

Иймд хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалт, Үндэсний Ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08), мөн Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний албаны тухай 88 дугаар конвенц, Ажил мэргэжлийн чиг баримжаа, ажилд зуучлах сэдвээр тусгайлсан сургалтыг зохион байгуулж байх хэрэгцээ байна.

Цахим сургалтын программ хангамж

Дээрхээс үндэслэн ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөрийг үр дүнтэй хүргэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудын чадавхийг сайжруулах зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд цахим сургалтын платформыг худалдаж авсан. 2022 оны 10 дугаар сард Цахим сургалтын программ хангамжийг Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) <https://surgalt.ndaatgal.mn/#/login> (түр нийлүүлэгч талын серверт) болон Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын <https://surgalt.hudulmur-halamj.gov.mn> серверт суулгаж хүлээлгэн өгсөн. Одоогоор тус сургалтын платформд НДЕГ-ын салбарын 1602 албан хаагч, ХХҮЕГ болон харьяа байгууллагын 915 орчин албан хаагч бүртгэлтэй байна.

Платформоор НДЕГ нь нийгмийн даатгалын салбарын албан хаагчдыг чадавхижуулах 13 модулийг байршуулан сургалт зохион байгуулж байна. ХХҮЕГ нь 12 сургалтын модуль байршуулан сургалт зохион байгуулж байна.

Цаашид салбарын ажилтнуудын чадавхийг системтэй, тасралтгүй хөгжүүлэхийн тулд цахим сургалтын платформд сургалтын хөтөлбөр, модуль боловсруулж баяжуулах шаардлагатай.

Энэхүү платформ нь байгууллагын дотоод сургалтыг онлайн орчинд шилжүүлж, цаг хугацаа, зардлыг хэмнэх, сургалтын хүртээмжийг сайжруулах ач холбогдолтой юм.

Дээрхээс үндэслэн ХНХЯ нь Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах шинэчлэгдэн боловсруулсан сургалтын материалыг видео болгон хөрвүүлэх зөвлөх компанийг авч ажиллуулахаар төлөвлөж байна.

Сургалтын материалыг аудио, видео, хөдөлгөөнт график, хөдөлгөөнт дүрс гэх мэт тайлбарлах аргын төрлүүдийг ашиглан модуль/материалыг цахим сургалтын платформд суурилсан сургалтын формат руу хөрвүүлэн цахим сургалтын платформд байршуулна.

Ажлын зорилго

Энэхүү ажлын даалгаврын зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах сургалтын материалыг видео болгон хөрвүүлэх. Ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлж хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэхэд илүү үр дүнтэй, чанартай хүргэхэд хувь нэмэр оруулна.

Ажлын хамрах хүрээ

1. ХАВСРАЛТ 1-д заасан модуль/материалыг сэдэв тус бүрээр техникийн үзүүлэлтийн дагуу видео, аудио, хөдөлгөөнт график, хөдөлгөөнт дүрс гэх мэт ашиглан цахим сургалтын платформд суурилсан сургалтын формат руу ХАВСРАЛТ 2-д заасан техникийн шаардлагын дагуу видео болгон хөрвүүлэх. Видео хичээлийн текстийг тусад нь татаж аван хэвлэх боломжтой байх;
2. ХНХЯ/ТХН-ийн санал хүсэлтэд үндэслэн цахим сургалтын видео хичээлийг эцэслэх;
3. Цахим сургалтын платформд байршуулахад дэмжлэг үзүүлэх;

Зөвлөх компани нь сургалтын модуль боловсруулж эхлэхийн өмнө ХНХЯ-ны цахим сургалтын платформын бүтэц, онцлогтой сайтар танилцсан байх ёстой.

Сургалтын

**модуль/материалыг
байршуулах платформ**

<https://surgalt.hudulmur-halamj.gov.mn>

Даалгавар 1.

Сургалтын модуль/материалыг цахим сургалтын платформд суурилсан формат руу хөрвүүлэх.

1. ХАВСРАЛТ 1-д заасан модуль/материалыг сэдэв тус бүрээр техникийн үзүүлэлтийн дагуу видео, аудио, хөдөлгөөнт график, хөдөлгөөнт дүрс гэх мэт ашиглан цахим сургалтын

платформд суурилсан сургалтын формат руу ХАВСРАЛТ 2-д заасан техникийн шаардлагын дагуу видео болгон хөрвүүлэх.

1.1 Мэргэжилтнүүдэд зориулсан унших материал бүрийг хавсаргах;

1.2 Модуль бүрийн сургалтын тестийн асуулт, хариултыг ойлгомжтой байдлаар оруулах;

1.3 Видео хичээлийн текстийг тусад нь татаж аван хэвлэх боломжтой байх;

2. Сургалтын видео хичээлийг ХНХЯ-д танилцуулж, хянуулах;

3. ХНХЯ-ны санал хүсэлтийн дагуу сургалтын видео хичээлийг эцэслэх.

Даалгавар 2.

Цахим сургалтын платформд байршуулах.

1. Сургалтын видео хичээлийг цахим сургалтын платформд байршуулахад дэмжлэг үзүүлэх;

Явцын тайлан, үр дүнг хянах:

Зөвлөх компани нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төсөл хэрэгжүүлэх нэгж болон Дэлхийн банкны удирдлаган дор ажиллана. Зөвлөх компанийн үйл ажиллагааг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ:

1. Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;

2. Нийлүүлэх үр дүнг заасан хугацаанд гүйцэтгэсэн байдал;

3. Гүйцэтгэсэн ажлын чанар;

Гэрээний хугацаа:

Зөвлөх компани **2024 оны 08-р сарын 09-оос 2024 оны 11-р сарын 20 хүртэл** ажиллана.

Зөвлөх компани нь цахим сургалтын платформын техникийн шаардлагад нийцсэн сургалтын модуль/материалыг видео руу хөрвүүлэхийн тулд ХНХЯ-ны цахим сургалтын платформыг нийлүүлэгч компанитай хамтран ажиллана.

Нийлүүлэх бүтээгдэхүүн	Нийлүүлэх хугацаа	Хяналт ба баталгаажуулалт
Нийлүүлэх бүтээгдэхүүн 1. (i) Хавсралт 1-д заасан 1.1 Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт (ҮАМАТ-08) (ii) 1.2 Ур чадварын багц, Ажил мэргэжлийн стандарт	2024.09.20	ХНХЯ/ТХН
Нийлүүлэх бүтээгдэхүүн 2. (i) 1.3 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох анхан шатны сургалт сэдвээр ХНХЯ-аас баталсан сургалтын дижитал модуль (ii) Хавсралт 1-д заасан 1.4 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ахисан түвшний сургалт	2024.10.20	ХНХЯ/ТХН

(iii) 1.5 Ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын дижитал сургалтын модуль		
<p>Нийлүүлэх бүтээгдэхүүн 3.</p> <p>(i) 1.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр баримталж буй Үндэсний бодлого, хөтөлбөр сэдвээр ХНХЯ-наас баталсан сургалтын дижитал модуль;</p> <p>(ii) 1.7 Сургагч багш бэлтгэх сургалт</p> <p>(iii) Сургалтын материалыг цахим сургалтын платформд https://surgalt.hudulmurhalamj.gov.mn байршуулахад дэмжлэг үзүүлж ажилласан ажлын тайлан</p> <p>(iv) Нийлүүлэх бүтээгдэхүүн 1-3-ын эцсийн тайлан;</p>	2024.11.20	ХНХЯ/ТХН

Эдгээр ажлуудыг гүйцэтгэхдээ ХНХЯ, ТХН-тэй нягт хамтран байнгын хэлэлцүүлэг, зөвлөгөөн, санал хүсэлтийг тусгаж ажиллана.

Төсөв:

Гэрээний нийт үнийн дүн **135.600.000** төгрөгөөс хэтрэхгүй.

Төлбөрийг дараах байдлаар 3 хувааж төлнө:

1. Нийлүүлэх бүтээгдэхүүн 1-ийн ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 30%
2. Нийлүүлэх бүтээгдэхүүн 2-ын ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 40%
3. Нийлүүлэх бүтээгдэхүүн 3-ын ажлыг гүйцэтгэснээр гэрээний нийт дүнгийн 30%

Тайлан:

Зөвлөх компани нь ХНХЯ/ТХН-д тайлагнана. Ажлын даалгаврын гүйцэтгэлийг ХНХЯ/ТХН хүлээн зөвшөөрснөөр бүх материалыг ХНХЯ/ТХН-д USB флаш дискэнд хуулан хүлээлгэн өгнө.

Зөвлөх компанид тавигдах шаардлага:

- Албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага/ төрийн бус байгууллага;
- Зөвлөх компани нь мэргэжлийн сургалт, насанд хүрэгчдийн сургалтыг видео контент болгон хөгжүүлэх чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх (өмнөх ажлын туршлага болон видео контент хөгжүүлж байсан туршлагыг баримтжуулсан нотлох баримтыг гаргаж өгөх шаардлагатай);
- Зөвлөх компани нь видео контент хөгжүүлэх тоног төхөөрөмжтэй байх. Камер, микрофон, гэрэлтүүлэг, видео засварлах программ хангамж зэрэг чанартай видео контент бэлдэх бүрэн тоног төхөөрөмжтэй байх.

Зөвлөх компани нь дараахь шаардлагыг хангасан гишүүдтэй байна.

Арга зүйн зөвлөх

- Контент үйлдвэрлэгч, харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй эсвэл холбогдох чиглэлээр магистрын зэрэгтэй;
- Боловсролын салбар болон харилцаа холбооны чиглэлээр таваас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Зохион байгуулалтын өндөр үр чадвартай;
- Монгол хэлний бичгийн өндөр чадвартай;
- Баг удирдах чадвартай;
- Мэдээлэл үр дүнг товч ойлгомжтой, зорилтот бүлгийн үзэгчдэд үр дүнтэй хүргэх чадвартай;
- Баримт бичиг боловсруулах өндөр үр чадвартай;

Сургагч багш

- Насанд хүрэгчдийн боловсрол олгогч, эсвэл багшлах чиглэлээр дор хаяж магистрын зэрэгтэй байх;
- Боловсролын салбарт 5-аас доошгүй жил ажилласан, сургалт заах, багшлах чиглэлээр дор хаяж 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Монгол хэлний бичгийн өндөр чадвартай;
- Илтгэх үр чадвартай;
- Багаар ажиллах чадвартай;
- Мэдээлэл үр дүнг товч ойлгомжтой, зорилтот бүлгийн үзэгчдэд үр дүнтэй хүргэх чадвартай;
- Баримт бичиг боловсруулах өндөр үр чадвартай;

График дизайнер (2 График дизайнер)

- График дизайнерын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Видео болон анимэйшн контент хөгжүүлэх 3-аас доошгүй төсөлд график дизайнер/зураачаар ажилласан туршлагатай;
- График дизайнер/зураачийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх;
- Багаар ажиллах чадвартай;
- Мэдээлэл үр дүнг товч ойлгомжтой, зорилтот бүлгийн үзэгчдэд үр дүнтэй хүргэх чадвартай;
- Баримт бичиг боловсруулах өндөр үр чадвартай;

ЗОХИОГЧИЙН ЭРХ

Гэрээний дагуу боловсруулсан бүх баримт бичиг болон материалыг ХНХЯ-ын зохиогчийн эрхээр хамгаална. Дээрх баримт бичиг болон материалыг ХНХЯ (зохиогчийн эрх эзэмшигч)-аас бусад аливаа этгээдэд задруулах, ашиглахыг хориглоно.

Зөвлөх компани нь зохиогчийн эрхийг хүндэтгэж, боловсруулсан агуулга, материалыг ХНХЯ (зохиогчийн эрх эзэмшигч)-аас бусад байгууллагад задруулахгүй, ашиглахыг хориглох “Баталгааны бичиг” ирүүлснээр аливаа зөрчил, зөрчлөөс зайлсхийнэ.

Зөвлөх компани нь гэрээний хүчинтэй байх хугацаа дуусах, дуусгавар болох хүртэл гэрээт ажилтай холбоотой бүх эх файлын бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах үүрэгтэй. Агуулга бүр зохиогчийн эрхгүй хөгжим, аудио, видео, зураг ашиглах ёстой. Зөвлөх компани нь зохиогчийн эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

ХАВСРАЛТ I. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТЫН МОДУЛЬ/МАТЕРИАЛЫГ ВИДЕО БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ					
#	Агуулга	Модуль	Хугацаа	Зорилтот бүлэг	Сургалтын хөтөлбөр
1. ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ТОДОРХОЙЛОЛТ (ҮАМАТ-08)					
1.1	Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт (ҮАМАТ-08)	<p>-ҮАМАТ гэж юу вэ?</p> <p>-Ажил, мэргэжлийн тодорхойлолт, ҮАМАТ-ийн бүтэц бүрэлдэхүүн, түүнд дүйцүүлэх боловсролын түвшин, дотоод бүтцэд байгаа ажил, мэргэжлийн бүлэг, дэд бүлгийн талаарх ойлголт</p> <p>-Ажил, мэргэжлийн оноосон нэр, индекс/код, 1 ба түүнээс дээш кодын утга учир, кодоор ажил, мэргэжлийг хайхад юуг анхаарах ёстой вэ?</p> <p>-“ҮАМАТ-08”-ын бүрэлдэхүүн, бүтэц тэдгээр нь кодтой хэрхэн уялдах вэ?</p> <p>-“Түлхүүр үг”-ийг тогтоох, түлхүүр үгээр ажил мэргэжлийг хайх нь</p> <p>-“ҮАМАТ-08”-ын хэрэглээ, практик амьдралд гарч буй зарим бэрхшээл, сургамж</p> <p>-“ҮАМАТ-08”-ын хэрэглээний явцад орсон албан ёсны өөрчлөлтүүд</p> <p>Суралцагчдад зориулсан унших материал:</p> <p>-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын өдрийн Олон улсын Ажил, мэргэжлийн стандарт ангилал-08 (ISCO-08)-ын үзэл баримтлал, суурь зарчимд дүйцүүлэн боловсруулсан Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (ҮАМАТ-08)</p>	35 минут (Сургалтын модуль бүрийн үргэлжлэх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна)	Зорилтот бүлэг: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт ажилтнууд	ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 2022 онд сургалтын материал, сургалтыг заах багшийн тайлбар, танилцуулга болон сургалтын явцад суралцагчдаас авах шалгалт/тестийн материалыг боловсруулсан.

		<p>-“YAMAT-08”-ын хэрэглээний явцад орсон албан ёсны өөрчлөлтүүд</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/139 тушаал;</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/179 тушаал;</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/332 тушаал;</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/208 тушаал;</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/143 тушаал;</p> <p>Шалгалтын асуулт, хариулт: 25 Асуулт, хариулттай</p>			
1.2	Ур чадварын багц, Ажил мэргэжлийн стандарт	<p>-Ур чадварын багцыг боловсруулахад Ажил мэргэжлийн стандарт ямар үүрэгтэй вэ</p> <p>-Ур чадварт суурилсан ажил зуучлал</p> <p>-Ажил мэргэжлийн стандарт (АМС) боловсруулах шаардлага</p> <p>-Боловсрогдсон АМС-үүд</p> <p>-АМС боловсруулах аргачлал</p> <p>-Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах Ур чадварын багц</p> <p>-Мэдлэг, Ур чадвар ба Чадавхи</p> <p>-Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн механикчийн жишээн дээр Ур чадварын багыг тодорхойлох нь</p> <p>-Ур чадварын багц ба 75 ажил мэргэжил</p> <p>Суралцагчдад зориулсан унших материал:</p>	45 минут (Сургалтын модуль бүрийн үргэлжлэх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна)	Зорилтот бүлэг: Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, холбогдох албан тушаалтан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт ажилтнууд	ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 2022 онд сургалтын материал, сургалтыг заах багшийн тайлбар, танилцуулга болон сургалтын явцад суралцагчдаас авах шалгалт/тестийн

		<p>-Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 04 тогтоолоор баталсан “Ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлал батлах тухай”</p> <p>-Хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай 75 ур чадварын багц</p> <p>Шалгалтын асуулт, хариулт: 3 Асуулт, хариулттай</p>			материалыг боловсруулсан.
1.3	Ажил мэргэжлийн баримжаа олгох суурь ур чадвар олгох сургалт	<p>Модуль 1: Ажил мэргэжлийн баримжаа олгох үндсэн үзэл баримтлал, зөвлөх үйлчилгээний суурь</p> <p>-Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин</p> <p>-Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний институтчилэл</p> <p>-Ажил мэргэжлийн зөвлөхийн чадамж</p> <p>Модуль 2: Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөхөд ашиглагддаг онол, үзэл баримтлал</p> <p>-Бие хүний мэргэжлийн хөгжлийн үйл явц, үе шат</p> <p>-Мэргэжлийн сонголтын онол, үзэл</p> <p>-Бие хүний сэтгэл зүйн шинж чанарууд</p> <p>Модуль 3:</p>	4 цаг (240 минут) (3 модуль 15 академик цагийн хичээл)	Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, холбогдох албан тушаалтан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт ажилтнууд	Европын холбооны санхүүжилттэй “Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд

		<p>Ажил мэргэжлийн зөвлөхийн мэдээллийн менежмент</p> <p>-Ажил мэргэжлийн мэдээллийн сан</p> <p>Шалгалтын асуулт, хариулт:</p> <p>ОБҮДХЭТ-ийн хүрээнд боловсруулсан шалгалтын асуулт, хариултыг оруулна.</p>			2024 онд боловсруулсан.
1.4	<p>Ажил мэргэжлийн баримжаа олгох зөвлөхийн ахисан түвшний сургалт</p>	<p>Модуль 1:</p> <p>Ажил мэргэжлийн зөвлөхийн ёс зүй, зөвлөхийн суурь чадамж</p> <p>-Зөвлөхийн ёс зүй</p> <p>-Зөвлөхийн суурь чадамж</p> <p>Модуль 2:</p> <p>Бие хүний үйлдэл ба шийдвэр гаргалт</p> <p>-Шийдвэр гаргах үйл явц</p> <p>-Хязгаарлагдмал рациональ шийдвэр гаргалт</p> <p>Модуль 3:</p> <p>Зөвлөгөө өгөх чадамж, арга техник</p> <p>-Зөвлөгөө өгөх үндсэн арга техник</p> <p>-Танин мэдэхүйн үл нийлцэл</p> <p>-Эганы зөвлөгөө өгөх заавар</p> <p>-Шийдэл төвт зөвлөгөө</p> <p>Модуль 4:</p> <p>Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор оношлогоо хийх арга зүй</p> <p>-Бие хүний мэргэжлийн хэв шинжийг тодорхойлох нь</p> <p>-Бие хүний сэтгэл зүйн шинж чанарыг оношлох нь</p> <p>Модуль 5:</p>	<p>6 цаг (360 минут)</p> <p>(45 академик цагийн хичээл)</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, холбогдох албан тушаалтан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт ажилтнууд</p>	<p>ХНХЯ-ны Онцгой байдлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд 2024 онд боловсруулж батлуулсны дараа видео болгон хөрвүүлнэ.</p>

		<p>Ажил мэргэжлийн зөвлөхийн мэдээллийн менежмент</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо ба оролцогч талууд</p> <p>-Боловсролын тогтолцоо ба оролцогч талууд</p> <p>Дадлагын ажил:</p> <p>Модуль 6:</p> <p>Зорилтот бүлгийн иргэдийн нийгэм, сэтгэл зүйн онцлог</p> <p>-Нийгмийн бүлгийн төрөл, хэлбэр</p> <p>-Зорилтот бүлгийн нийгэм-сэтгэл зүйн онцлог</p> <p>Модуль 7:</p> <p>Бүлгийн зөвлөгөө, сургалт зохион байгуулах арга зүй</p> <p>-Бүлгийн зөвлөгөөний үндсэн ойлголт, арга зүй</p> <p>-Сургалт зохион байгуулах арга, техник</p> <p>Шалгалтын асуулт, хариулт:</p> <p>ОБҮДХЭТ-ийн хүрээнд боловсруулсан шалгалтын асуулт, хариултыг оруулна.</p>			
1.5	Ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалт	<p>Ажилд зуучлах стратеги</p> <p>-Ажилд зуучлах тогтолцоо, үйлчилгээний үндсэн үүрэг</p> <p>-Ажилд зуучлах стратеги</p> <p>Шалгалтын асуулт, хариулт:</p> <p>ОБҮДХЭТ-ийн хүрээнд боловсруулсан шалгалтын асуулт, хариултыг оруулна.</p>	<p>3 цаг (180 минут)</p> <p>(2 модуль 10 академик цагийн хичээл)</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, холбогдох албан тушаалтан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын</p>	<p>ХНХЯ-ны Онцгой байдлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд 2024 онд боловсруулж батлуулсны дараа</p>

				салбарын нийт ажилтнууд	видео болгон хөрвүүлнэ.
1.6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр баримталж буй Үндэсний бодлого, хөтөлбөр	<p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр баримталж буй төрийн бодлого, хөтөлбөр-Хууль эрх зүйн орчин</p> <p>-Алсын хараа - 2050</p> <p>-“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтнй (үйлчилгээний) албаны тухай 88 дугаар конвенц</p> <p>-Ниймийн зарим бүлгүүдэд түлхүү анхаарах чиглэлээр</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтинй үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын талаар</p> <p>Шалгалтын асуулт, хариулт: 7 Асуулт, хариулттай</p>	50 минут (Сургалтын модуль бүрийн үргэлжлэх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна)	Зорилтот бүлэг: Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, холбогдох албан тушаалтан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт ажилтнууд	ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 2022 онд сургалтын материал, сургалтыг заах багшийн тайлбар, танилцуулга болон сургалтын явцад суралцагчдаас авах шалгалт/тестийн материалыг боловсруулсан.
1.7	Сургагч багш бэлтгэх сургалт	<p>Модуль -1</p> <p>Удиртгал хичээл/хичээлийн дэг, сургалтын хүлээлт/ -Дасгал ажил: багш гэж хэн бэ?</p> <p>-Сургагч багш гэж хэн бэ? /ёс зүй, мэдлэг, ур чадвар, хандлага, имидж бүрдүүлэлт, биеийн хэлэмж/ -Дасгал ажил: Та хэрхэн суралцдаг вэ?</p>	4 цаг (240 минут) (2 модуль 10 академик цагийн хичээл)	Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, холбогдох албан тушаалтан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын	ХНХЯ-ны Онцгой байдлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд 2024 онд боловсруулж батлуулсны дараа

		<p>-Сургалтанд оролцогчдын ялгаатай байдлыг харгалзан үзэх нь</p> <p>-Насанд хүрэгчдийн сургалтын онцлог</p> <p>Модуль-2</p> <p>Сургалтын хэрхэн зохион байгуулах вэ?/процессын зураглал хийх/</p> <p>-Бүлгийн ажил: Процессын зураглал гаргах</p> <p>-Сургалтын төлөвлөгөө боловсруулах арга техник</p> <p>-Сургалтын төлөвлөгөө боловсруулах арга техник</p> <p>-Бүлгийн ажил: сургалтын хөтөлбөр боловсруулах</p> <p>-Сургалтын үнэлгээний арга, хэрэгсэл боловсруулах</p> <p>-Сургалтын бэлтгэл хангах нь /анги танхим, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн/-1</p> <p>Модуль-3</p> <p>Сургалтын үндсэн арга</p> <p>-Сургалтын үндсэн аргууд</p> <p>-“Do-it” Дадлага ажил</p> <p>-Сургалтын үнэлгээ</p> <p>Шалгалтын асуулт, хариулт:</p> <p>ОБҮДХЭТ-ийн хүрээнд боловсруулсан шалгалтын асуулт, хариултыг оруулна.</p>		салбарын нийт ажилтнууд	видео болгон хөрвүүлнэ.
--	--	---	--	-------------------------	-------------------------

Нийт үргэлжлэх хугацаа 19 цаг 20 минут.

ХАВСРАЛТ II. ОНЛАЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Зөвлөх компани нь онлайн сургалтын модуль/материалыг видео болгон хөрвүүлэхдээ дараах зарчмуудыг баримтална:

- i. Сэдэв бүрийн унших материалын жагсаалтын холбоосыг хавсаргах;
- ii. Модуль бүрийн сургалтын тестийн асуултанд хариулах хэд хэдэн хэлбэрүүд (олон хариултаас нэгийг сонгох, олон хариултаас олныг сонгох, хэрэглэгч өөрөө бичиж оруулах)-ээс бүрдэнэ. Сонгох хариултын хэлбэрүүд зураг, видео, текст байж болно.
- iii. Сэдвийн агуулгыг ойлгоход хялбар болгох үүднээс энгийн бөгөөд сонирхолтой байдлаар тайлбарлах.
- iv. PowerPoint илтгэлийн арын фон нь цайвар, ногоон, цэнхэр, харин бичвэрүүд нь бараан өнгөтэй байна. Төрөл бүрийн тод өнгө ашиглахгүй.
- v. Сургалтын төгсгөлд ажилчдын мэдлэгийг үнэлэхэд шаардлагатай дизайны шийдлүүдийг ашиглах;
- vi. Дууны нягтрал нь арын чимээ шуугиангүйгээр бичигдсэн байх бөгөөд дууны түвшин хэт зөөлөн эсвэл хэт чанга байхгүй.
- vii. Видео бичлэгүүдийг төрийн хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудад зориулсан онлайн сургалтын платформ дээр байршуулах болно. Дараах шаардлагыг хангасан байна.
 - Full HD 1920 x 1080 бичлэг хийх төхөөрөмжтэй байх;
 - Видео гаралт нь mp4 байх;
 - Видео нь чанартай , тогтвортой, гэрэлтүүлэгтэй байх;
 - Аудио нь тод, арын чимээ шуугиангүй байх.